

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 2-р сарын 27-өд

Дугаар 24/01/02 Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 78-р зүйлийн 78.1 дэх заалт, нэр дэвшүүлэх хорооноос оруулсан саналыг үндэслэн **ТОГТООХ нь:**

3. Тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон 9 гишүүний 100 хувийн саналаар Гомбо овогтой Оюунболд ТУЗ-ийн даргаар сонгосугай.
4. Компанийн холбогдох бичиг баримтанд компанийг төлөөлж гарын үсэг зурах, компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхийг ТУЗ-ийн дарга Г.Оюунболдод олгосугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

1. Ц.Сарантуяа

2. А.Ариунтуяа

3. Р.Отгонбат

4. А.Ариун-Эрдэнэ

5. Ганзориг Халиунаа

6. Б.Батцэцэг

7. Ганчимэг Халиунаа

8. Г.Оюунболд

9. Б.Хосбаяр

Handwritten signatures for the board members listed on the left. The signatures are written in black ink over a red circular stamp that contains the text 'BLUE SKY SECURITIES JSC' and 'УЛААНБААТАР ХОТ'.

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 2-р сарын 27 өдөр

Дугаар *23/01/03*

Улаанбаатар хот

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ
СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8. дах заалт, Нэр дэвшүүлэх хороо болон ТУЗ-ийн даргаас оруулсан саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

5. Тус компанийн 2023 оны 2-р сарын 27 өдрийн ТУЗ-ийн хуралд оролцсон 9 гишүүний 100 хувийн саналаар Ундармаа овогтой Анарыг Гүйцэтгэх захирлаар улируулан ажилуулсугай.
6. Компанийн тухай хууль, компанийн дүрэмд нийцүүлэн гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулан уг гэрээнд ТУЗ-ийг төлөөлөн гарын үсэг зурахыг ТУЗ-ийн дарга /Г.Оюунболд/-д зөвшөөрсүгэй.
7. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, хөлсөөр ажиллах гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг шинээр сонгогдсон Гүйцэтгэх захирал У.Анарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

G. OYUNBOLD
Г.ОЮУНБОЛД



“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 2-р сарын 27 өдөр

Дугаар 23/а/04 Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ХОРООДЫГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 81-р зүйлийн 81.2. дах заалт, ТУЗ-ийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн Аудитын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
 1. Б.Батцэцэг /Дарга/
 2. Ц.Сарантуяа
 3. А.Ариунтуяа
2. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
 1. Г.Халиунаа /Дарга/
 2. Ц.Сарантуяа
 3. Г.Оюунболд
3. ТУЗ-ийн Цалин урамшууллын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
 1. Г.Халиунаа /Дарга/
 2. Б.Батцэцэг
 3. Р.Отгонбат
4. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, Хороодын үйл ажиллагааны журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  Т.ОЮУНБОЛД



“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 2-р сарын 27 өдөр

Дугаар

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫГ ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8. дах заалт, Нэр дэвшүүлэх хороо болон ТУЗ-ийн даргаас оруулсан саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн хуралд оролцсон нийт 9 гишүүний 100 хувийн саналаар компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар А.Амирланг томилсугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан нарийн бичгийн даргын эрх үүргийг үндэслэн А.Амирлантай байгуулах ажил гүйцэтгэх гэрээг хавсралтаар баталсугай.
3. ТУЗ-ийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурахыг ТУЗ-ийн дарга Г.Оюунболдод зөвшөөрсүгэй.
4. Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон ажил гүйцэтгэх гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг А.Амирланд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  Г.ОЮУНБОЛД

